Завхан аймгийн зарим сумдын гэр хорооллолд амьдардаг эмэгтэйчүүдийн ундны усны талаарх мэдлэгийн судалгаа

Л.Баярмагнай[1], Д.Ням-Осор[1], Ч.Өнөрцэцэг[1]

[1]Нийгмийн эрүүл мэндийн сургууль, АШУҮИС
Email: Bayarmagnai.l@mnums.edu.mn, Утас:88775558

Түлхүүр үг:
Ундны ус
Ундны усны эх үүсвэр

Товч утга:
Үндэслэл: Хүн амын эрүүл мэндийг хамгаалах асуудлын нэг нь хүний өдөр тутам хэрэглэдэг унд, ахуйн ус хангамж, хүрэлцээ, чанар, аюулгүй байдлын асуудал юм. АШҮҮИС-ийн НЭМС-иас 2016 онд хийсэн Улаанбаатар хотын гэр хорооллын хүн амын “Ундны усны талаарх мэдлэг, хандлага, дадлын судалгаа”-нд хамрагдсан нийт өрхийн 86.7 хувь нь ус хадгалдаг, 30.6 хувь нь ус зөөх сав нь шаардлага хангаагүй буюу зориулалтын бус усны сав ашиглаж байсан. Мөн 10 өрх тутмын 7 нь өрхийн ундны ус болон усны савны эрүүл ахуйн байдал нь хангалтгүй байсан[8]. Бидний судалгааны үндсэн зорилго нь эмэгтэйчүүдийн дундах ундны усны талаарх мэдлэгийг үнэлэхэд оршино. **Судалгааны арга:** Судалгааг Завхан аймгийн зарим сумдын гэр хорооллын өрхийн хүн амын дунд агшингийн судалгаанд суурилж явуулсан. Судалгаанд нийтдээ Завхан аймгийн 5 сумын 1260 өрхийн 2520 хүн ам хамруулсан. **Үр дүн:** Оролцогчдоос хүний бие мах бодийн нийт усны хэмжээний агууламж гэсэн хариултанд эмэгтэйчүүдийн 34,7% нь зөв хариулсан бол, 58,6% нь буруу хариулсан бөгөөд 6.7% нь мэдэхгүй гэж хариулжээ. Судалгаанд оролцогчдын 50.7% нь усаа ундны усны зориулалтын бус саваар зөөдөг, 33.2% нь усны зориулалтын цэвэр саваар зөөдөг гэж хариулсан бол 16.1% нь энэ талаарх мэдээлэлгүй бөгөөд мэдэхгүй гэж хариулсан болно. Усны бохирдлоос сэргийлэх талаарх асуултанд таван хүн тутмын гурав нь усаа буцалгаж хэрэглэдэг гэж хариулсан бол, гурван хүн тутмын нэг нь усны саваа тагтай байлгах, гурван хүн тутмын хоёр нь усны саваа тогтмол угаадаг, 23.4% нь гараа тогтмол угаадаг гэсэн бол 9 оролцогч энэ талаар огт мэдлэггүй гэж хариулт өгсөн. Ус цэвэрхэн тунгалаг бол шууд ууж болох талаар асуултад 43% нь буцалгаж ууж болно, 15.5% нь болохгүй гэсэн хариулт өгч 41.5% нь буруу хариулт өгсөн байна. Усаа хадгалах тохиоромжтой хугацааны талаарх асуултанд нийт оролцогчдын 77.2% нь зөв мэдээлэлтэй байсан бол 22.8% нь хангалтгүй мэдээлэлтэй байсан. **Дүгнэлт:** Эмэгтэйчүүдийн ундны ус, ус хадгалах савны талаарх мэдлэг хангалтгүй байна гэж дүгнэгдсэн. Мөн усны бохирдох шалтгааны талаарх мэдлэг хангалгүй байсан.

Үндэслэл: Хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах асуудлын нэг нь хүн амын өдөр тутамдаа хэрэглэдэг ундны ус юм. Манай улсад НҮБ болон ДЭМБ-ын дэмжлэгээр НЭМХ-д 2010 онд хийсэн “Өрхийн усны чанар, ариун цэвэр, эрүүл ахуйн талаарх хүн амын мэдлэг,дадал, хандлагын судалгаа”-аар судалгаанд хамрагдсан өрхүүдийн талаас илүү хувь нь усны саваа 3 хоноод усаар зайлж угаадаг гэж хариулсан нь ус хадгалах болон зөөх савны цэвэрлэгээний ач холбогдлыг төдийлөн ойлгодоггүй болохыг харуулж байна[1].

Бага наснаасаа усыг түүхийгээр уух дадалтай, усыг буцалгаж хэрэглэдэггүй 56,1% нь түүхий ус уугаад сурчихсан гэжээ. Хуванцар савны хэрэглээ эрс нэмэгдэж, стандартын шаардлага хангаагүй хуванцар савыг ундны усны сав болгон ашиглаж байгаа нь хот, хөдөөд ялгаагүй дийлэнх нь хэрэглэсээр байна.

НЭМХ-ийн судлаач нарын “Микробиологийн хурдавчилсан шинжилгээний аргаар ундны усны чанар, усны савны бохирдлыг судалсан дүн” судалгаагаар өрхийн ус хадгалах зөөх саван дахь усны гэдэсний бүлгийн нянгийн бохирдол нь ундны усны эх үүсвэрийн усанд агуулагдаж буй гэдэсний бүлгийн нянгийн бохирдлоос их байсан нь гэрийн нөхцөлд ус их бохирдож байгааг харуулж байна[2]. Ундны усыг хадгалах, зөөх савнуудад нянгийн бохирдол их байгаа нь бохир сав, шанага зэргээр дамжин ундны усны ундны ус бохирдох нөхцөл болж байжээ[2-3]. Устай холбоотой өвчин эмгэг нь усны эх үүсвэрийн аюулгүй байдлаас гадна усыг айл өрхийн түвшинд


зөөх, хадгалах, хэрэглэх үед хэрэглэгчийн буруу зан үйл, эрүүл мэндийн боловсрол хангалтгүй байх зэрэгтэй холбоотой байдаг[1-3]. Дээрх судалгааны үр дүнг үндэслэн эмэгтэйчүүдийн ундны усны талаарх мэдлэгийг судлахыг зорьсон юм.

Зорилго: Завхан аймгийн зарим сумдын гэр хороололд амьдардаг эмэгтэйчүүдийн ундны усны эрүүл ахуйн талаарх мэдлэгийг судлахад оршино.

Зорилт: Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн ундны усны талаарх мэдлэгийг тодорхойлох


Материал арга зүй: Уг судалгаанд өрхөд суурилсан агшингийн загварыг ашиглан 1260 насанд хүрсэн хүн хамруулсан. Судалгаанд хамрагдахаар сонгогдсон өрхийн гишүүдээс асуумжаар мэдлэгийг тодорхойлж, өрхийн ундны усны саванд арчдас болон нянгийн шинжилгээ хийгдсэн.

Үр дүн: Судалгаанд нийт 1260 насанд хүрсэн хүн хамрагдсанаас 779 эмэгтэй (61.8%) байна. Эмэгтэйчүүдийн дундаж нас 41±7, хамгийн залуу нь 26, ахмад нь 65 настай, 1.9% нь боловсролгүй, 7.2% нь бага, 15.3% нь суурь, 31.5% нь бүрэн дунд, 10.3% нь тусгай дунд, 33,9% нь дээд боловсролтой байна. Хүний биеийн хэдэн хувийг ус эзэлдэг тухай асуултанд судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 34.7% нь зөв, 58.6% нь буруу, 6.7% нь мэдэхгүй гэж хариулжээ.




Зураг 1. Ус дутагдсанаар хүний биед илрэх шинж тэмдэгүүд

Ус дутагдсанаас хүний биед илрэх шинж тэмдгүүдээс цангах гэж нийт эмэгтэйчүүдийн 87.3% нь хариулжээ.




Зураг 2. Шаардлага хангасан ундны усны эх үүсвэр

Шаардлага хангасан ундны усны талаар 3 хүн тутмын 1 нь мэдлэг сайн байна. Усны бохирдлоос сэргийлэх аргын талаар асуултанд 5 хүн тутмын 3 нь усыг буцалгаж хэрэглэх, усны саваа тогтмол цэвэрлэх болон усны саваа тагтай байлгах гэж 3 хүн тутмын 1 хариулсан бол 23.4 % нь гараа тогтмол угаах гэж хариулжээ.




Зураг 3. Усаа зориулалтын саваар зөөдөг эсэх

Ундны усаа зориулалтын бус саваар зөөж хадгалж байгаа, зориулалтын сав хэрэглэж байгаа эсэхээ мэдэхгүй гэж 16% нь хариулжээ.



Зураг 4. Усны савны тэмдэг, тэмдэглэгээ

Асуултанд хариулсан байдлаас харвал хуванцар савны тэмдэг, тэмдэглэгээний талаар мэдлэг муутай байна. Өрхөөр явж ундны усны савыг судлах явцад дийлэнхи өрх тэмдэг, тэмдэглэгээгүй сав, 3, 4, 6, 7 болон будаг зуурмагны сав хэрэглэж байгаа нь ажиглагдсан.



Зураг 5. Гэрийн нөхцөлд ундны ус хадгалах тохиромжтой хугацаа

Судалгаанд оролцогчдын 77.2% нь зөв хариулсан бол 22.8% нь ус хадгалах тохиромжтой хугацааг мэдэхгүй байна.

Дүгнэлт: Усны хүний биед гүйцэтгэх үүрэг, ундны усны зориулалтын савны талаарх мэдлэгийн түвшин хангалтгүй байна. Ус бохирдох нөхцөл шалтгааны талаар эмэгтэйчүүдийн мэдлэг хангалтгүй байна.

Хүснэгт 1. Эмэгтэйчүүдийн ундны усны талаарх мэдлэгийн үнэлгээ

	Маш сайн	сайн	дунд	муу	Маш муу
Эмэгтэй	1.4	13.9	37.7	42.6	4.4

Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн ундны усны талаарх мэдлэг хангалтгүй байна. Эмэгтэйчүүд ундны устай холбоотой хамгийн их мэдээлэл авахыг хүсч буй сэдвүүдэд хадгалалт, цэвэршүүлэлт, уснаас шалтгаалах өвчлөл багтаж байна. Энэ чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулбал эрэлт хэрэгцээ их байгааг судалгааны үр дүн илэрхийлж байна.

Талархал: Бидний судалгааны ажлыг гүйцэтгэхэд хэрэгжүүлэгч АШУҮИС, НЭМС, Завхан аймгийн эрүүл мэндийн газар, санхүүжүүлэгчээр UNISEF хамтарч ажиллалаа. Хамтран ажиллахад дэмжлэг туслалцаа үзүүлсэн судалгааны баг хамт олон, судалгаанд оролцогч хүүхэд, эцэг эхчүүдэд талархал илэрхийлье.

Ном зүй:

1. *НЭМҮТ, НҮБ-ын хүүхдийн сан Сургууль болон өрхийн түвшинд ус цэвэршүүлэх, аюулгүй хадгалах. Сургагч багш нарт зориулсан гарын авлага, аргачлал, зөвлөмж. УБ хот, 2014 он х 31, 35-45, 68-75*
2. *ЭМЯ, ДЭМБ, МАУА, Орчны эрүүл мэндийн судалгаа. Өрхийн усны чанар, ариун цэвэр эрүүл ахуйн талаарх хүн амын мэдлэг, дадал, хандлагын судалгаа. УБ хот 2010 он х 270-272, 294-314*
3. *ЭМЯ, ДЭМБ, МАУА, Монгол улсад эрүүл мэндийн салбар үүсэж хөгжсөний 90 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл. Өрхийн ус, ариун цэвэр эрүүл ахуйн талаарх мэдээлэл сургалт сурталчилгааны хэрэгцээг тодорхойлсон судалгааны дүн. УБ хот, 2011 он, х 50-52*
4. *ЭМЯ, НҮБ-ын ХС, АШУҮИС-ийн НЭМС, Орон нутагт усны аюулгүй байдлын төлөвлөгөө хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын тайлан, УБ, 2017 он*
5. *https://www.who.int/water_sanitation_health/publications/2011/9789241548151_ch05.pdf*
6. *WASH situation in Mongolia and survey data sources, WHO/ UNICEF JMP: www. washdata.org*
7. *УБ хотын 2016 оны УСУГ-ын гүйцэтгэлийн тайлан, Усны хэрэглээ*
8. *АШУҮИС, GN INGO, Улаанбаатар хотын зарим дүүргийн гэр хорооллын хүн амын ундны ус болон амны хөндийн эрүүл ахуйн талаарх мэдлэг, хандлага, дадлын судалгааны тайлан, УБ, 2016 он, х55-56*

Ger district`s women knowledge of drinking water in some province Zavkhan

Bayarmagnai.L[1], Nyam-Osor.D[1], Unurtsetseg.Ch[1]

[1]School of Public Health , MNUMS
Email: Bayarmagnai.l@mnums.edu.mn, Tel:88775558

Introduction: An arising public health concern of our daily lives is a drinking water and its coverage, quality and safety issues. Therefore, our study purpose is to identify knowledge of drinking water among women.
Study methodology: This is a population based cross-sectional study design and included 2520 people of 1260 families in five soums.
Study results: Knowledge assessment made with question of total percentage of body water, 34.7% answered correctly and 58.65% answered incorrectly. Rest of the respondents said 6.7% do not know. The fifty one percent of the study participants brought drinking water by inappropriate bottle and 33.2% of them said appropriate bottle was used. 16.1% of them do not know about. Among water pollution questions, 3 per 5 persons boiled drinking water whereas 1 per 3 persons left drinking water with bottle hat and 2 per 5 persons washed their drinking bottle. The 23.4% of the study participant wash their hand and nine study participants don not know. If water looks clear and pure, 43% of them, can drink.
Conclusion: Among women knowledge of drinking water was not satisfactory. Additionally, lack of information causes of water pollution.

Key words: Drinking water